

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР**

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2011 ОНЫ 10 ДУГААР САРЫН СТАТИСТИК
ҮЗҮҮЛЭЛТИЙН ТОЙМ, МЭРГЭЖЛИЙН
ОРОЛЦОГЧ БАЙГУЛЛАГУУДЫН 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ**

ТАНИЛЦСАН:

ХОРООНЫ ДАРГА:

Д.БАЯРСАЙХАН

ХОРООНЫ ГИШҮҮН:

Б.ДААЖАМБА

Г.ХЭРЛЭН

АЖЛЫН АЛБАНЫ ДАРГА:

Х.БУМ-ЭРДЭНЭ

ХЯНАСАН:

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗРЫН ДАРГЫН

Б.САРУУЛ

ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

ҮЦГ-Н ХЗЗМОХ-ИЙН ДАРГЫН ҮҮРГИЙГ

ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

А.АВИР

НЭГТГЭСЭН: ҮНЭТ ЦААСНЫ ГАЗРЫН

ХЯНАН ШАЛГАГЧ:

Ц.ЦЭРЭНТОГТОХ

**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН 2011 ОНЫ ГУРАДУГААР УЛИРЛЫН
БАЙДЛААРХ АРИЛЖАА, ТӨЛБӨР ТООЦООНЫ СТАТИСТИК
ҮЗҮҮЛЭЛТҮҮД.**

Хавсралт -1

| <i>Үзүүлэлтүүд</i> | <i>2011 оны 7 дугаар сар</i> | <i>2011 оны 8 дугаар сар</i> | <i>2011 оны 9 дүгээр сар</i> | <i>2011 оны 10 дугаар сар</i> |
|---|----------------------------------|----------------------------------|----------------------------------|-----------------------------------|
| Арилжаа явагдсан өдөр | 18 | 23 | 22 | 21 |
| Үнэт цаас нь бүртгэгдсэн компанийн тоо Үүнээс: | 334 | 334 | 334 | 330 |
| <i>Төрийн өмчийн</i> | 23 | 23 | 23 | 23 |
| <i>Төрийн өмчийн оролцоотой</i> | 29 | 29 | 29 | 29 |
| <i>Хувийн өмчийн</i> | 282 | 282 | 282 | 278 |
| Зах зээлийн үнэлгээ /тэрбум төгрөг / | 2155.8 | 2055.5 | 2003.5 | 2287.4 |
| Үнэт цаасны гүйлгээний дүн /төгрөгөөр/ Үүнээс: | - | - | - | - |
| <i>Компанийн хувьцаа</i> | 6,274,547,550 | 6,401,960,542 | 2,003,513,207 | 28,999,180,539 |
| <i>Засгийн газрын бонд</i> | 18,990,000,000 | 109,975,000,000 | 26,204,000,000 | 21,801,500,000 |
| <i>Компанийн бонд</i> | - | - | 3,841,630,000 | 361,580,000 |
| Арилжигдсан үнэт цаасны тоо Үүнээс: | | | | |
| <i>Компанийн хувьцаа</i> | 3,136,392 | 22,407,902 | 4,799,895 | 7,628,944 |
| <i>Засгийн газрын бонд</i> | 189,900 | 1,099,750 | 262,040 | 218,015 |
| <i>Компанийн бонд</i> | - | - | 384,163 | 36,158 |
| Дундаж ханш /Өдрийн дундаж хувьцааны арилжаагаар / Үүнээс: | | | | |
| <i>Компанийн хувьцаа</i> | 348,585,975 | 278,346,111 | 91,068,782 | 1,380,913,359 |
| <i>Засгийн газрын бонд</i> | - | - | 13,102,000,000 | 10,900,750,000 |
| <i>Компанийн бонд</i> | - | - | 768,326,000 | 90,395,000 |
| ТОП-20 индекс | | | | |
| <i>Дундаж индекс</i> | 20,930.68 | 20,744.88 | 19,767.35 | 20,662.0 |
| <i>Хамгийн их</i> | 21,754.01 | 21,173.96 | 20,170.83 | 21,341.25 |
| <i>Хамгийн бага</i> | 19,710.57 | 20,013.72 | 19,450.59 | 19,737.69 |
| <i>Хаалт</i> | 21,218.73 | 20,119.01 | 19,757.96 | 21,257.67 |
| Төвлөрсөн хадгаламжинд нээгдсэн данс / тухайн сард/ Үүнээс: | | | | |
| <i>Аж ахуйн нэгж байгууллага</i> | 16 | 27 | 37 | 38 |
| <i>Хувь хүн</i> | 9,811 | 12,129 | 10454 | 10,714 |
| Хугацааны эцэст /өссөн дүнгээр/ Үүнээс: | | | | |
| <i>Аж ахуйн нэгж байгууллага</i> | 1377 | 1404 | 1441 | 1479 |
| <i>Хувь хүн</i> | 498,551 | 510,680 | 521,134 | 531,848 |
| Нийт хийгдсэн хэлцлийн тоо /өссөн дүнгээр / | 28,141 | 31,919 | 34,794 | 38,852 |
| <i>Тухайн сард хийгдсэн хэлцэл</i> | 2,318 | 3,778 | 2,875 | 4,058 |

“МХБ” ХК-иас МС-1-1 маягтуудын дагуу Хороонд ирүүлсэн 2011 оны 3 дугаар улирал мэдээлэл.

1.1. Үнэт цаасны зах зээлийн 10 дугаар сарын байдлаарх арилжааны төлөв:

2011 оны 10 дугаар сард Монголын хөрөнгийн бирж дээр нийт 21 удаагийн арилжаа явагдаж компанийн 7,628,944 ширхэг хувьцаа 28,999,180,539 төгрөгөөр, Засгийн газрын 218,015 ширхэг бонд 21,801,500,000 төгрөгөөр, компанийн 36,158 ширхэг бонд 361,580,000 төгрөгөөр тус тус арилжаалагдаж нийт 51,162,260,539 төгрөгийн үнийн дүн бүхий гүйлгээ хийгдсэн нь өмнөх сарын дүнтэй харьцуулахад 1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Хүснэгт-1

| Үзүүлэлтүүд | 2011 оны 8 дугаар сар | 2011 оны 9 дүгээр сар | 2011 оны 10 дугаар сар |
|--|-----------------------|-----------------------|------------------------|
| Арилжаа явагдсан өдөр | 23 | 22 | 21 |
| Арилжигдсан үнэт цаасны үнийн дүн /төгрөгөөр/ Үүнээс: | | | |
| Компанийн хувьцаа | 6,401,960,542 | 2,003,513,207 | 28,999,180,539 |
| Засгийн газрын бонд | 109,975,000,000 | 26,204,000,000 | 21,801,500,000 |
| Компанийн бонд | - | 3,841,630,000 | 361,580,000 |
| Арилжигдсан үнэт цаасны тоо Үүнээс: | | | |
| Компанийн хувьцаа | 22,407,902 | 4,799,895 | 7,628,944 |
| Засгийн газрын бонд | 1,099,750 | 262,040 | 218,015 |
| Компанийн бонд | - | 384,163 | 36,158 |
| Дундаж ханш /Өдрийн дундаж хувьцааны арилжаагаар / Үүнээс: | | | |
| Компанийн хувьцаа | 278,346,111 | 91,068,782 | 1,380,913,359 |
| Засгийн газрын бонд | - | 13,102,000,000 | 10,900,750,000 |
| Компанийн бонд | - | 768,326,000 | 90,395,000 |

2011 оны 10 дугаар сард Монголын хөрөнгийн биржийн арилжаалагаар Ремикон, АПУ, Сор, Женко тур бюро, Эрдэнэт хүнс, Таван толгой зэрэг хувьцаат компанийн ханш өссөн бол Хөх ган, Монголиа девелопмент ресорсес, Оллоо, Гермес центр, Силикат зэрэг хувьцаат компаниудын хувьцааны ханш буурсан үзүүлэлттэй байна.

График-1



Хүснэгтээс харахад Монголын хөрөнгийн бирж дээр 2011 оны 9 дүгээр сард 2,003,513,207 төгрөгийн үнэ бүхий 4,799,895 ширхэг хувьцаа арилжаалагдсан бол мөн оны 10 дугаар сард 7,628,944 ширхэг хувьцааг 28,999,180,539 төгрөгөөр арилжаалсан байгаа өмнөх сараас даруй 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.


Зах зээлийн үнэлгээ 2010 оны 10 дугаар сарын байдлаар 2 их наяд 287 тэрбум 492 сая 917 мянган төгрөгт хүрсэн нь өмнөх сарын дүнгээс 14 хувь буюу 284.5 тэрбум төгрөгөөр, өмнөх оны жилийн эцсийн дүнгээс даруй 6 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График-2



Хөрөнгийн зах зээлийн ерөнхий хандлагыг илэрхийлж буй ТОП-20 индекс 2011 оны 10 дугаар сарын байдлаар хамгийн их 21,341.25, хамгийн бага 19,737.69, дундаж индекс 20,662.0 нэгж байна. ТОП-20 индекс өмнөх сарын мөн үеийнхээс даруй 894.65 нэгжээр өссөн байна.

График-3



2011 оны 10 дугаар сарын байдлаар салбарын индексийн үзүүлэлтүүдийг авч үзвэл аж үйлдвэрийн салбарын индекс 19.52, Хөдөө аж ахуйн салбарын индекс 239.82, Уул уурхайн салбарын индекс 756.31, Худалдаа үйлчилгээний салбарын индекс 35.99 нэгжээр тус тус өссөн бол барилга тээврийн салбарын индекс -117.98 нэгжээр буурсан үзүүлэлттэй байна.

Барилга, тээврийн салбарын индекс буурсан шалтгааны тухайн салбарын улирлын чанартай үйл ажиллагаа явуулдагтай холбоотой гэж үзэв.

2011 оны 10 дугаар сард анхдагч зах зээлд Шарын гол ХК-ийн 11,177 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,646,257 ширхэг хувьцааны арилжаа явагдсан байна.

2.2. Үнэт цаасны зах зээлийн 10 дугаар сарын байдлаарх төлбөр, тооцоо хадгаламжийн төлөв:

2011 оны 10 дугаар сарын байдлаар “ҮЦГТТХТ” ХХК-д 756,702,985,320 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 17,947,994,983 ширхэг үнэт цаас хадгалагдаж байгаагаас 5 хувиас дээш хувь эзэмшдэг 261, 10 хувиас дээш хувь эзэмшдэг 768, 33 хувь буюу түүнээс дээш хувь эзэмшдэг 252 хувьцаа эзэмшигч бүртгэлтэй байна.

Мөн тайлант хугацаанд үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төвийн 3432 харилцагчийн дансанд 26,491,774.5 төгрөгийн орлого, 3611 харилцагчийн дансанд 28,260,806.6 төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус гүйцэтгэжээ.

Засгийн газрын бондын хувьд 15 харилцагчийн 23,113,745.2 төгрөгийн орлого, 13 харилцагчийн 23,302,626.4 төгрөгийн зарлагын гүйлгээг хийж гүйцэтгэсэн байна.

Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төвд 2011 оны 10 дугаар сард нийт 10,752.0 данс нээгдсэнээс дансны төрлөөр үзвэл шинээр 10,373, ХОЭБ-ээр 378, хүсэлтээр 1, данс нээгдсэн байна. Харилцагчийн төрлөөр авч үзвэл Монгол Улсын иргэн 10,686.0, гадаадын иргэн 28, Монголын дотоодын аж ахуй нэгж 32, гадаадын аж ахуй нэгж 6 дансыг тус тус нээжээ. 10 дугаар сард нээсэн нийт дансны тоог өмнөх сарын мөн үетэй харьцуулахад 261 дансаар нэмэгдсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд улсын хэмжээнд өссөн дүнгээр нийт 533,327 данс нээгдээд байна.

Хүснэгт-2

| Он | Дансны төрөл | | | Харилцагчийн төрөл | | | | Нийт | Холболт |
|---------|--------------|------|--------|--------------------|--------|--------|--------|-------|---------|
| | Шинэ | ХОЭБ | Хүсэлт | Иргэн | | ААН | | | |
| | | | | Монгол | Гадаад | Монгол | Гадаад | | |
| 2011/01 | 274 | 69 | 149 | 454 | 30 | 6 | 2 | 492 | 187 |
| 2011/02 | 2942 | 113 | 208 | 3163 | 53 | 44 | 3 | 3263 | 586 |
| 2011/03 | 156 | 132 | - | 270 | 15 | 2 | 1 | 288 | 693 |
| 2011/04 | 10322 | 645 | - | 10723 | 29 | 214 | 1 | 10967 | 2017 |
| 2011/05 | 7263 | 487 | 527 | 8174 | 42 | 58 | 3 | 8277 | 1489 |
| 2011/06 | 9157 | 381 | 113 | 9549 | 59 | 39 | 4 | 9651 | - |
| 2011/07 | 9549 | 278 | - | 9775 | 36 | 11 | 5 | 9827 | 760 |
| 2011/08 | 11805 | 351 | - | 12053 | 76 | 22 | 5 | 12156 | 1305 |
| 2011/09 | 10167 | 322 | 2 | 10403 | 51 | 35 | 2 | 10491 | 1343 |
| 2011/10 | 10373 | 378 | 1 | 10686 | 28 | 32 | 6 | 10752 | 1254 |

3.3. Үнэт цаасаар гэрчлэгдсэн өмчлөх эрхийг арилжааны бусаар шилжүүлсэн гүйлгээний мэдээлэл:

2011 оны 10 дугаар сарын байдлаар 14032 ширхэг хувьцааг өв залгамжлалаар, 169,273 ширхэг хувьцааг шүүхийн шийдвэр үүргийн гүйцэтгэл хангуулахаар шилжүүлсэн бол 786,620 ширхэг хувьцааг эрх бүхий байгууллагын шийдвэрээр чөлөөлсөн байна.

Эрх бүхий байгууллагын шийдвэрээр 7,413,417 ширхэг, шүүх, цагдаагийн байгууллагын шийдвэрээр 1014 ширхэг, зээлийн барьцаанд 10,319,256 ширхэг хувьцааг тус тус тусгаарласан байна.

2011 оны 10 дугаар сарын байдлаар Хорооноос тусгай зөвшөөрөл аван үйл ажиллагаа явуулж буй арилжаа эрхлэх 1, төлбөр тооцоо хадгаламжийн 1, брокер, дилерийн 88 компани байгаагаас давхардсан тоогоор андеррайтерийн тусгай зөвшөөрөлтэй 22, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх 16 компани байна.

2011 оны 10 дугаар сард брокер, дилерийн 3 компани хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, дүрмийн сангийн хэмжээнд өөрчлөлт оруулсан бол, Очир-Эрдэнэ инвест ХХК гүйцэтгэх захирлыг өөрчилсөн бол брокер, дилер, андеррайтерийн Нортенсек ХХК оноосон нэрээ Ард капитал групп болгон өөрчилсөн бол Эм даблью Ти Эс ХХК Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хархорум сумуудад салбар байгуулах зөвшөөрлийг Хорооны даргын тушаалаар аваад байна. Хорооноос орон нутагт брокер, дилерийн компанийн салбарын үйлчилгээ үзүүлэх эрх авсан нийт 19 компани байна.


График-4



2011 оны 10 дугаар сарын байдлаар 334 хувьцаат компани Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэйгээс төрийн өмчийн 23, төрийн өмчийн оролцоотой 29, хувийн өмчийн 282 компани байна. Оны эхнээс нийт 25 хувьцаат компани ногдол ашиг тараахаар шийдвэрлэсэн байна.

График-5

Ногдол ашиг тараалтын байдал (2001-2011/10)



4.4. 2011 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН НЭГТГЭЛ:

2011 оны 3 дугаар улирлын байдлаар мэргэжлийн оролцогч байгууллагуудын актив, пассивын бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараахь байдалтай байна.

2011 оны 3 дугаар улирлын байдлаар мэргэжлийн оролцогч байгууллагын нийт активын хэмжээ 98.0 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 69.5 тэрбум төгрөгөөр буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Үүнд 2011 он гарсанаас хойш хөрөнгийн зах зээл идэвхжиж, Хорооноос зах зээл дээр брокер, дилерийн үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн тоо эрс нэмэгдсэнтэй холбон үзэж байна. Мөн хөрөнгийн зах зээлийг арилжааны томоохон банкууд сонирхож банк өөрөө болон охин компаниараа дамжуулан брокер, андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авч үйл ажиллагаа явуулж байгаа нь салбарын нийт активын дүнг өсгөх үндсэн шалтгаан болжээ.

Салбарын хэмжээнд нийт хөрөнгийн 89 хувийг Би Ди Сек ХК, Монголын хөрөнгийн бирж ХК, Монгол секюритис ХК, ҮЦТТГХТ ХХК, Фронттиер ХХК, Нортенсек ХХК, Евразиа Капитал Монголиа ХХК, Ти Ди Би ХХК, Туушин инвест зэрэг 9 компани бүрдүүлж байна.

Нийт активын дүнд эргэлтийн хөрөнгө 91.2 хувь, эргэлтийн бус хөрөнгийн дүн 8.8 хувийг тус тус эзэлж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад эргэлтийн хөрөнгийн нийт хөрөнгөд эзлэх хувь 14.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Эргэлтийн хөрөнгийн бүтцийг задалж үзвэл мөнгөн хөрөнгө 76.4%, богино хугацаат хөрөнгө оруулалт 14%, авлага 4.7%, бараа материал 0.2%, урьдчилж төлсөн зардал 4.7% -иар тус тус бүрдүүлж байна.

Эргэлтийн бус хөрөнгийг үндсэн хөрөнгө 79.6%, бусад үндсэн хөрөнгө 7.0%, биет бус хөрөнгө 3.4%, бусад хөрөнгө 10%-иар тус тус бүрдүүлж байна. Эргэлтийн бус хөрөнгийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулахад даруй 1.9 тэрбум төгрөгөөр буюу 30 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


| МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧ БАЙГУУЛЛАГУУДЫН БАЛАНСЫН ХУУРАНГУЙ НЭГТГЭЛ | 2011 оны 3 дугаар улирал | 2010 оны 3 дугаар улирал | Өөрчлөлт |
|--|-----------------------------|-----------------------------|--------------------------|
| Хөрөнгө | 98,016,984,838.34 | 28,489,896,390.21 | 69,527,088,448.13 |
| Эргэлтийн хөрөнгө | 89,385,204,176.92 | 21,848,144,338.57 | 67,537,059,838.35 |
| Мөнгөн хөрөнгө | 68,246,778,217.79 | 12,474,494,240.55 | 55,772,283,977.24 |
| Богино хугацаат хөрөнгө оруулалт | 12,566,844,940.80 | 3,900,171,692.56 | 8,666,673,248.24 |
| Авлага | 4,232,462,790.53 | 3,200,882,324.59 | 1,031,580,465.94 |
| Бараа материал | 138,701,174.10 | 117,299,965.61 | 21,401,208.49 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 4,145,293,995.38 | 952,499,519.95 | 3,192,794,475.43 |
| Үнэт цаасны бодит үнэ цэнийн тохируулга /+,-/ | - | 1,207,181,271.09 | (1,207,181,271.09) |
| Үнэт цаасны болзошгүй эрсдлийн сан | - | (4,384,675.78) | 4,384,675.78 |
| Бусад | 55,123,058.31 | - | 55,123,058.31 |
| Эргэлтийн бус хөрөнгө | 8,631,780,661.42 | 6,641,752,051.64 | 1,990,028,609.78 |
| Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч | 98,016,984,838.34 | 28,489,896,390.21 | 69,527,088,448.13 |
| Өр төлбөр | 49,342,722,783.90 | 12,185,265,790.73 | 37,157,456,993.17 |
| Богино хугацаат өр төлбөр | 42,694,984,810.73 | 11,112,721,927.22 | 31,582,262,883.51 |
| Урт хугацаат өр төлбөр | 6,647,737,973.17 | 1,072,543,863.51 | 5,575,194,109.66 |
| Эзэмшигчдийн өмч | 48,674,262,054.44 | 16,304,630,599.48 | 32,369,631,454.96 |
| Өмч: Төрийн өмч | 2,335,886,599.18 | 2,335,886,599.18 | - |
| Хувийн өмч | 38,622,196,461.27 | 10,361,496,813.63 | 28,260,699,647.64 |
| Халаасны хувьцаа | 0.00 | - | - |
| Хувьцаат капиталын дүн | 40,958,083,060.45 | 12,697,383,412.81 | 28,260,699,647.64 |
| Нэмж төлөгдсөн капитал | 3,355,753,594.72 | 3,060,329,861.54 | 295,423,733.18 |
| Дахин үнэлгээний нөөц | 143,717,526.67 | 117,604,977.79 | 26,112,548.88 |
| Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг | 1,154,301,887.83 | 494,600,399.06 | 659,701,488.77 |
| Үнэт цаасны хэрэгжээгүй олз, гарз | 2,341,020,023.92 | 1,337,646,033.82 | 1,003,373,990.10 |
| Эрсдлийн сан | 203,650,303.41 | 125,903,823.58 | 77,746,479.83 |
| Хуримтлагдсан ашиг, алдагдал | 517,735,657.44 | (1,528,837,909.12) | 2,046,573,566.56 |
| Тайлангийн үеийн | 1,309,680,444.28 | (685,599,969.07) | 1,995,280,413.35 |
| Өмнөх үеийн | -791,944,786.84 | (843,237,940.05) | 51,293,153.21 |
| Үүнээс: цөөнхийн хувь оролцоо | 0.00 | 0.00 | 0.00 |

2011 оны 3 дугаар улирлын нийт пассивын дүнд өр төлбөрийн дүн 50.3 хувь, эзэмшигчийн өмчийн дүн 49.6 хувийг тус тус эзэлж байна.

Өр төлбөрийн нийт дүнд богино хугацаат өр төлбөр 86.5 хувийг, урт хугацаат өр төлбөр 13.5 хувийг тус тус эзэлж байна. Өр төлбөрийн дүн өмнөх оны мөн үеийнхээс даруй 37.1 тэрбум төгрөг буюу 3 дахин нэмэгдсэн байна.

Эзэмшигчийн өмчийн дүнд хувьцаат капиталын дүн 84.1 хувь, хуримтлагдсан ашиг, алдагдал 1.2 хувь, бусад 14.7 хувийг тус тус эзэлж байна.

Нийт салбарын активын хэмжээ 98.0 тэрбум төгрөгт хүрсэн нь даатгалын салбарын нийт активын дүнгээс даруй 20.6 тэрбум төгрөгөөр, хадгаламж зээлийн салбарын нийт активын дүнгээс даруй 38.7 тэрбум төгрөгөөр тус тус илүү байна.



2011 оны 3 дугаар улирлын байдлаар мэргэжлийн оролцогч байгууллагуудын орлого, үр дүнгийн тайлангийн нэгтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл дараахь байдалтай байна.

2011 оны 3 дугаар улирлын байдлаар үндсэн үйл ажиллагааны орлого 11.6 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеийнхээс даруй 8.4 тэрбум төгрөгөөр буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Нийт үндсэн үйл ажиллагааны орлогын 75.2 хувийг Би Ди Сек ХК, Монголын хөрөнгийн бирж ХК, Фронтнер ХХК, Финанс линк ХХК, Ти Ди Би ХХК зэрэг 6 компани бүрдүүлж салбарын хэмжээнд ашигтай үзүүлэлт гарсан боловч 3 дугаар улирлын байдлаар нийт 41 компани алдагдалтай ажилласан байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогын бүтцийг үйл ажиллагааны орлого 47.9 хувь, хөрөнгө оруулалтын орлого 8.6 хувь, борлуулалтын бусад орлого 43.5 хувиар тус тус бүрдүүлж байна. Нийт ашиг 10.3 тэрбум төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеээс 7.6 тэрбум төгрөгөөр буюу 3 дахин өссөн үзүүлэлттэй байна. Салбарын хэмжээнд 1.2 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллаж 340 сая төгрөгийн орлогын татвар төлсөн байна.

Хүснэгт-4

| <i>Мэргэжлийн оролцогч байгууллагуудын 3 дугаар улирлын орлого, үр дүнгийн тайлангийн хураангуй нэгтгэл</i> | 2011 оны 3 дугаар улирал | 2010 оны 3 дугаар улирал | Өөрчлөлт |
|---|---------------------------------|---------------------------------|-------------------|
| <i>Үндсэн үйл ажиллагааны орлого</i> | 11,672,949,735.03 | 3,253,950,239.73 | 8,418,999,495.30 |
| <i>Үйл ажиллагааны орлого</i> | 5,697,043,259.74 | 2,754,801,224.39 | 2,942,242,035.35 |
| <i>Хөрөнгө оруулалтын орлого</i> | 1,060,303,024.33 | 499,981,234.09 | 560,321,790.24 |
| <i>Бусад</i> | 4,915,603,450.96 | 79,601.84 | 4,915,523,849.12 |
| <i>Борлуулалтын хөнгөлөлт</i> | 0.00 | (480,984.00) | 480,984.00 |
| <i>Борлуулалтын хорогдол ба буцаалт</i> | 10,467,635.37 | (430,836.59) | 10,898,471.96 |
| <i>Үндсэн үйл ажиллагааны цэвэр борлуулалтын орлогын дүн</i> | 11,662,482,099.66 | - | 11,662,482,099.66 |
| <i>Борлуулсан үнэт цаасны өртөг</i> | 1,335,890,269.03 | 762,742,304.54 | 573,147,964.49 |
| <i>Нийт ашиг (алдагдал)</i> | 10,326,591,830.63 | 2,491,207,935.19 | 7,835,383,895.44 |
| <i>Үйл ажиллагаа (борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал</i> | 8,746,335,005.08 | 3,095,035,404.83 | 5,651,299,600.25 |

| | | | |
|---|------------------|------------------|------------------|
| | | | |
| <i>Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)</i> | 1,580,256,825.54 | 250,720,809.92 | 1,329,536,015.62 |
| <i>Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)</i> | 10,962,348.71 | (353,106,659.72) | 364,069,008.43 |
| <i>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</i> | 1,591,219,174.25 | (404,172,379.87) | 1,995,391,554.12 |
| <i>Орлогын татварын зардал</i> | 340,255,045.28 | 51,065,720.15 | 289,189,325.13 |
| <i>Татварын дараах ашиг (алдагдал)</i> | 1,250,964,128.97 | - | 1,250,964,128.97 |
| <i>Цөөнхөд ноогдох хувь</i> | 0.00 | (685,599,969.07) | 685,599,969.07 |
| <i>Ердийн үйл ажиллагааны ашиг (алдагдал)</i> | 1,250,964,128.97 | (281,427,589.20) | 1,532,391,718.17 |
| <i>Онцгой шинэжтэй зүйл - цэвэр</i> | 0.00 | (685,599,969.07) | 685,599,969.07 |
| <i>Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)</i> | 1,250,964,128.97 | (685,599,969.07) | 1,936,564,098.04 |
| <i>Нэгж хувьцаанд ногдох ашиг (алдагдал)</i> | 0.00 | 0.00 | 0.00 |

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР